



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2022/2/НА-СА-ТШЗ

Цахим хуудас:
peakomaudit@gmail.com
Дархан-Уул аймаг
2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**
Утас: **7037-3089**
Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn
Ахлах аудитор: **С.Батцэцэг**
Утас: **7037-3089**
Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn
Аудитор: **А. Мөнхцэцэг**
Утас: **9906-9301**
Цахим хаяг: peakomaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

45059 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

ДАРХАН УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН
ИТХ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.БОЛДБААТАР ТАНАА

2022.02.25 № 156
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Дархан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

/Ш.МӨНХБАЯР/



009020267

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,008,620.00	4,636,120.00
33	АВЛАГА	0.00	500,000.00
33500	Бусад авлага	0.00	500,000.00
33510	Байгууллагаас авах авлага	0.00	500,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	3,008,620.00	4,136,120.00
35400	Хангамжийн материал	3,008,620.00	4,136,120.00
35410	Бичиг хэргийн материал	76,800.00	827,800.00
35420	Аж ахуйн материал	2,931,820.00	3,308,320.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	15,719,257.95	10,454,361.29
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,719,257.95	10,454,361.29
39200	Биет хөрөнгө	15,157,108.03	10,173,286.41
39203	Авто-тээврийн хэрэгсэл	18,800,000.00	18,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-12,533,333.44	-17,233,333.48
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	8,883,700.00	11,883,700.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-7,180,196.69	-8,576,624.67
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,787,223.00	22,787,223.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,600,284.84	-17,487,678.44
39300	Биет бус хөрөнгө	562,149.92	281,074.88
39301	Програм хангамж	1,574,300.00	1,574,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,012,150.08	-1,293,225.12
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	18,727,877.95	15,090,481.29
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	18,727,877.95	15,090,481.29
51	Засгийн газрын хувь оролцоо	18,727,877.95	15,090,481.29
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	14,784,909.00	14,784,909.00
51200	Хуримтлагдсан үр дүн	3,752,522.49	115,125.83
51210	Өмнөх үеийн үр дүн	14,511,796.05	3,752,522.49
51220	Тайлант үеийн үр дүн	-10,759,273.56	-3,637,396.66
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	190,446.46	190,446.46
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	18,727,877.95	15,090,481.29

Пийк-Ом Аудит ХХК

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	263,955,800.00	261,543,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,200,000.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,200,000.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,200,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,200,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	262,755,800.00	261,543,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,500,000.00	17,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000.00	17,300,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	261,255,800.00	244,243,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	261,255,800.00	244,243,700.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	274,715,073.56	265,181,096.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	274,715,073.56	265,181,096.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	204,478,256.86	190,503,152.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	159,014,696.00	132,310,686.14
210101	Үндсэн цалин	101,442,368.00	52,160,739.48
210102	Нэмэгдэл	8,305,200.00	18,086,626.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,741,800.00	3,556,672.00
210104	Урамшуулал	47,525,328.00	58,506,648.66
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,232,465.24	16,581,071.82
210201	Тэтгэврийн даатгал	12,729,784.48	11,258,871.82
210202	Тэтгэмжийн даатгал	1,468,032.72	1,334,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	932,100.00	1,050,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	314,000.00	267,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,788,548.04	2,669,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,440,000.00	2,370,000.00
210304	Байрны түрээс	2,440,000.00	2,370,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,079,894.06	12,422,319.58
210401	Бичиг хэрэг	3,074,200.00	6,304,100.00
210402	Тээвэр, шатахуун	3,307,200.00	3,091,680.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	650,994.06	748,839.58
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,047,500.00	2,277,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	962,000.00	1,398,500.00
210604	Урсгал засвар	962,000.00	1,398,500.00
2107	Томилолт, зочны зардал	277,090.00	0.00
210702	Дотоод албан томилолт	277,090.00	0.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,554,438.00	428,958.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,291,900.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	112,300.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	71,280.00	80,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,958.00	41,958.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	35,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,917,673.56	24,991,616.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	16,627,720.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	99,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,917,673.56	8,264,896.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,236,816.70	74,677,944.46
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	62,000,000.00	62,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	62,000,000.00	62,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,147,000.00	9,073,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	6,313,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,147,000.00	2,760,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,089,816.70	3,604,744.46
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,089,816.70	3,604,744.46
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-10,759,273.56	-3,637,396.66
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-10,759,273.56	-3,637,396.66

Пийк-Ом Аудит ХХК

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	14,784,909.00	190,446.46	14,511,796.05	29,487,151.51
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,784,909.00	190,446.46	14,511,796.05	29,487,151.51
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-10,759,273.56	-10,759,273.56
10	2020 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	14,784,909.00	190,446.46	3,752,522.49	18,727,877.95
11	2021 оны 1-р сарын 1-нээх үлдэгдэл	14,784,909.00	190,446.46	3,752,522.49	18,727,877.95
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,784,909.00	190,446.46	3,752,522.49	18,727,877.95
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-3,637,396.66	-3,637,396.66
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	14,784,909.00	190,446.46	115,125.83	15,090,481.29

Пийк-Ом Аудит ХХК

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	263,955,800.00	261,543,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,200,000.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,200,000.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,200,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,200,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	262,755,800.00	261,543,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,500,000.00	17,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000.00	17,300,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	261,255,800.00	244,243,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	261,255,800.00	244,243,700.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	263,955,800.00	258,543,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	263,955,800.00	258,543,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	193,426,983.30	182,525,755.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	157,508,501.95	130,894,937.96
210101	Үндсэн цалин	50,942,693.46	50,278,199.96
210102	Нэмэгдэл	17,768,067.26	18,086,626.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,861,347.00	4,285,072.00
210104	Урамшуулал	85,936,394.23	58,245,040.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,574,659.29	18,018,600.00
210201	Тэтгэврийн даатгал	13,277,459.29	12,680,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,570,700.00	1,333,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,260,400.00	1,067,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	315,200.00	267,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,150,900.00	2,669,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,440,000.00	2,370,000.00
210304	Байрны түрээс	2,440,000.00	2,370,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,897,794.06	6,745,659.58
210401	Бичиг хэрэг	2,271,800.00	3,217,900.00
210402	Тээвэр, шатахуун	3,307,200.00	2,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	650,994.06	727,059.58
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	667,800.00	600,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,073,500.00	1,463,500.00
210604	Урсгал засвар	1,073,500.00	1,463,500.00
2107	Томилолт, зочны зардал	277,090.00	0.00
210702	Дотоод албан томилолт	277,090.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,655,438.00	928,958.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,392,900.00	500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	112,300.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	71,280.00	80,000.00

Дархан-Уул аймгийн Дархан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,958.00	41,958.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	35,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	22,104,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	22,005,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	99,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,528,816.70	76,017,944.46
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	62,000,000.00	62,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	62,000,000.00	62,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,439,000.00	9,913,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	6,313,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,439,000.00	3,600,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,089,816.70	4,104,744.46
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,089,816.70	4,104,744.46
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	3,000,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	3,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	3,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	3,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	3,000,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	-3,000,000.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	0.00
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	0.00	0.00
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	244,243,700.00	240,638,955.54	(3,604,744.46)	98.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	244,243,700.00	240,638,955.54	(3,604,744.46)	98.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	172,430,500.00	168,825,755.54	(3,604,744.46)	97.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	133,477,200.00	130,894,937.96	(2,582,262.04)	98.07
210101	Үндсэн цалин	50,278,200.00	50,278,199.96	(0.04)	100.00
210102	Нэмэгдэл	18,501,400.00	18,086,626.00	(414,774.00)	97.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,752,000.00	4,285,072.00	(466,928.00)	90.17
210104	Урамшуулал	59,945,600.00	58,245,040.00	(1,700,560.00)	97.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,019,500.00	18,018,600.00	(900.00)	100.00
210201	Тэтгэврийн даатгал	12,680,400.00	12,680,400.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,334,800.00	1,333,900.00	(900.00)	99.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,067,800.00	1,067,800.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	267,000.00	267,000.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,669,500.00	2,669,500.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,775,000.00	2,370,000.00	(405,000.00)	85.41
210304	Байрны түрээс	2,775,000.00	2,370,000.00	(405,000.00)	85.41
2104	Хангамж, бараа материалын зардал	6,619,800.00	6,445,659.58	(174,140.42)	97.37
210401	Бичиг хэрэг	3,118,300.00	3,117,900.00	(400.00)	99.99
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,800.00	727,059.58	(173,740.42)	80.71
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,700.00	600,700.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,480,000.00	4,463,500.00	(16,500.00)	99.63
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	1,480,000.00	1,463,500.00	(16,500.00)	98.89
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	443,800.00	428,958.00	(14,842.00)	96.66
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	80,000.00	80,000.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	52,900.00	41,958.00	(10,942.00)	79.32
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,900.00	22,000.00	(3,900.00)	84.94

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	35,000.00	35,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,205,200.00	6,204,100.00	(1,100.00)	99.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,106,200.00	6,105,100.00	(1,100.00)	99.98
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	99,000.00	99,000.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	71,813,200.00	71,813,200.00	-	100.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	62,000,000.00	62,000,000.00	-	100.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	62,000,000.00	62,000,000.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,813,200.00	9,813,200.00	-	100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,313,200.00	6,313,200.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,500,000.00	3,500,000.00	-	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	244,243,700.00	240,638,955.54	(3,604,744.46)	98.52
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	158,841,600.00	240,638,955.54	81,797,355.54	151.50
320001	Орон нутгийн төсвөөс	158,841,600.00	240,638,955.54	81,797,355.54	151.50
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	85,402,100.00	-	(85,402,100.00)	1.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	85,402,100.00	-	(85,402,100.00)	1.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	12.00	12.00	-	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	5.50	5.50	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	2.00	1.00	200.00
620002	Гүйцэтгэх ажилтан	3.50	2.50	(1.00)	71.43
620004	Гэрээт ажилтан	1.00	1.00	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	5.50	5.50	-	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	2.00	2.00	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1.50	1.50	-	100.00
650010	Гэрээт ажилтан	1.00	1.00	-	100.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	1.00	1.00	-	100.00

Пийк-Ом Аудит ХХК

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	17,300,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	17,300,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	16,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	300,000.00
210401	Бичиг хэрэг	0.00	100,000.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	200,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	15,900,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	600000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		00.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	500,000.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	500,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	17300000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	17,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	17,300,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

Пийк-Ом Аудит ХХК

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд цалингийн зардалтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор А. Мөнхцэцэг, аудитор А. Батболд гүйцэтгэж, чанарын хяналтыг “Пийк-Ом Аудит” ХХК-ны чанарын хяналтын менежер Б. Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк Ом Аудит ХХК-нд 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2/14 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дархан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь “Нутгийн удирдлагыг төрийн удирдлагатай хослуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах” гэсэн зорилго зорилгын дэвшүүлэн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Дархан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж болон орон тоо байхгүй.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 274,715.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 5,494.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн

материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4,395.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дархан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,637.4 мянган төгрөгөөр буюу 19.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	500.0	500.0
Бараа материал	3,008.6	4,136.1	1,127.5
Үндсэн хөрөнгө	15,719.2	10,454.3	(5,264.9)
Нийт хөрөнгө	18,727.8	15,090.4	(3,637.4)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	18,727.8	15,090.4	(3,637.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	18,727.8	15,090.4	(3,637.4)

Бараа материал дансны үлдэгдэл 1,127.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд 14,164.5 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 13,037.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны хувьд тайлант онд төсвийн хөрөнгөөр 3,000.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж худалдан авч, 8,264.9 мянган төгрөгийн элэгдэл байгуулснаар оны эцэст 10,454.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 15,090.4 мянган төгрөг болж 3,637.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,412.1 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар буурсан нь туслах үйл ажиллагааны орлого 1,200.0 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 9,534.0 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан нь бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 4,291.9 мянга, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардал 1,769.8 мянган төгрөгөөр буурснаас голлон нөлөөлсөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар дахин үнэлгээний нэмэгдэлтэй хөрөнгийг акталснаас дахин үнэлгээний нэмэгдэл дансанд өөрчилөлт ороогүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 158,589.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 59,340.7 мянган төгрөгөөр өсгөж 217,930.5 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төсөлд цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 110,565.8 мянган төгрөгөөр төсөвлөсөн нь өнгөрсөн оны батлагдсан төсвөөс 48,448.9 мянга, тайлант оны батлагдсан төсвөөс 21,744.9 мянган төгрөгөөр тус тус багаар төсөвлөсөн байна.

Төсвийн тодотголоор 244,243.7 мянган төгрөг болгож 26,313.2 мянган төгрөгөөр өсгөн нь Засгийн газрын дотоод шилжүүлэг буюу намын суудлын мөнгийн нэмж баталсантай холбоотой юм.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 244,243.7 мянган төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 158,841.6 мянга, урьд оны үлдэгдлээс санхүүжилтээс 85,402.1 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 244,243.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 240,639.0 мянган төгрөгийг зарцуулж орон нутгийн төсөвт 3,604.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 240,639.5 мянган төгрөг буюу 98.52 хувьтай байна. 2021 онд цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 2,582.2 мянга, тогтмол зардал 405.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт санхүүжилтээр дээд шатны төсвийн захирагчаас 17,300.0 мянган төгрөг орж ирсэнээс бараа үйлчилгээний бусад зардал 15,900.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 500.0 мянга, хангамж, бараа материалын зардал 300.0 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 100.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж 500.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн нь авлагаар тусгасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

3.8 Аудитын гол асуудал

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын явцад шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд тайлант хугацаанд оруулбал зохиох 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 141 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцорсон 8 мэдээлэл байна. Мэдээлэл хоцорсон шалтгаан нь тухайн хугацаанд нягтлан бодогч Ж.Амаржаргал нь Ковид-19 цар тахлын халдварын улмаас эмнэлэгт хэвтэн

эмчлүүлж, интернет орчинд ажиллах боломжгүй байсныг эрхлэгчийн 2022 оны 2 сарын 15-ны 08 дугаар албан бичгээр баталгаажуулсан.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар шилэн дансны мэдээлэлд зарлагын 3 мэдээлэл оруулаагүй, ИТХ-ын хуралдааны зардалд гарсан материалыг тооцооны дансаар дамжуулан бүртгэлгээгүй, үлдэх өртөггүй хөрөнгийг дахин үнэлэх, шийдвэрлэх гэсэн зөвлөмжүүдийн биелэлтийг 2021 оны 10 сарын 13-ны өдрийн 2/140 тоот албан бичигээр ирүүлсэн ба тайлагналын дараах үе шатанд дахин хянахад хэрэгжилт 66.6 хувьтай байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,220.0 мянган төгрөгийн 2 алдаа зөрчил илэрсэнд 1 албан шаардлага хүргүүлж, 2,220.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.3 Албан шаардлага

Өмнөх оны аудитаар шилэн дансны мэдээлэлийг бүрэн оруулах, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах гэсэн зөвлөмж өгсөн, тайлант онд шилэн дансны цахим мэдээлэлд 10 мэдээлэл бүрэн оруулаагүй, хугацаа хоцроож мэдээлсэн

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2-д "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.5, 6.6, 6.7, 6.8 дахь заалтуудтай нийцэхгүй, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн:

Монгол улсын ерөнхий аудиторын А/95 дугаар тушаалын 4.2.1.10 -д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасны дагуу албан шаардлага хүргүүлэх. хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримт бүрдүүлэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд 2,220.0 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мян төгрөгөөр/							
				Үүнээс				Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дархан-Уул аймгийн Дархан сумын ИТХ	2	2,220.0	-	-	-	-	1	0	1	2,220.0
	Дүн	2	2,220.0	0	0	0	0	1	0	1	2,220.0

ПИЙК-ОМ АУДИТ ХХК

2022.02.25